



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/21

Ховд

Г Эзэмшил газрын хэмжээ, талбай
өөрчлөх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Олзвойн 1 дүгээр гудажны 06 тоотод байрлах Жужуухайн Цэн-Ойдовын /ПЮ60041576/ 2000 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 2141 метр квадрат, Ц.Олзвойн 2 дугаар гудамжны 204 тоот болгон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 6 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэрт байрлах Прокурорын газрын /9066438/ 1400 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 1199 метр квадрат, Заны 1 дүгээр гудамжны 108 тоот болгон албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Олзвойн 1 дүгээр гудамжны 13 тоотод байрлах Янпилын Нарангэрэлийн /ПЮ64042811/ 700 метр газрыг мэдээлийн сангийн зургийн дагуу 906 метр квадрат, Ц.Олзвойн 3 дугаар гудамжны 313 тоот болгон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 5 жилийн хугацаагаар,

4. Жаргалант сумын Наран багийн нутаг дэвсгэрт байрлах Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежийн /9069038/ 24000 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 5155 метр квадрат, Орчлон 5 дугаар гудамжны 502 тоот болгон боловсролын байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

5. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэрт байрлах Нийгмийн даатгалын хэлтсийн /9067655/ 500 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 934 метр квадрат, Ану хатан-2 дугаар гудамжны 202 тоот болгон төрийн захиргааны байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

6. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Нийгмийн халамж үйчилгээний хэлтсийн /9068139/ 9247,1 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 9248 метр квадрат, Ану хатан 1 дүгээр гудамжны 112 тоот болгон төрийн захиргааны байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

7. Жаргалант сумын Наран багийн нутаг дэвсгэрт байрлах Жаргалант сумын хот тохижуулах газрын /8262373/ 4626 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 4417 метр квадрат, Нарлаг 1 дүгээр гудамжны 110 тоот болгон албан хэрэгцээний зориулалтаар 8 жилийн хугацаагаар,

8. Жаргалант сумын Алагтолгой багийн нутаг дэвсгэрт байрлах Автотээврийн төв /5324165/-ийн 3000 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 5585 метр квадрат, Баянбулаг 3 дугаар гудамжны 307 тоот болгон албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

9. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын газрын /9067868/ 200 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 600 метр квадрат, Лааганы 1 дүгээр гудамжны 102 тоот болгон албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.

10. Газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа дээрх аж ахуйн нэгжэд газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

11. Газар эзэмших эрх баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ